

ХАРЬЦУУЛСАН ТЕНДЕРИЙН УРИЛГА

Огноо: 2017 оны 05-р сарын 25-ны өдөр

Гэрээний нэр, дугаар: АХО-2017-4

Төслийн нэр, дугаар: Дээврийн засварын ажил хийх, гүйцэтгэгчийг сонгох харьцуулсан тендер

“Монголросцветмет” ХХК нь эрх бүхий тендерт оролцогчдыг “Хэнтий аймгийн Бор-Өндөр суманд үйл ажиллагаа явуулж буй “Монголросцветмет” ХХК-ний харьяа “Бор-Өндөр”-ийн УБҮ-ийн уулын цех, уулын цехийн шүршүүр, баяжуулах фабрикийн шүршүүр нийт 1411,8 м² талбай бүхий дээврийг 148,4 м² цоройлтын хамт хийж гүйцэтгэх харьцуулсан тендерт оролцохыг урьж байна.

Харьцуулсан тендерт оролцогч нь техникийн болон санхүүгийн дараах шаардлагыг хангасан байна.

Д/д	Шаардлага	Тайлбар
Дээврийн ажлыг хийж гүйцэтгэх компанид тавигдах санхүүгийн шаардлага:		
1	2015 ба 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан аудитаар баталгаажсан байх	
2	Борлуулалтын хэмжээ: /сүүлийн 1 жилд гүйцэтгэсэн борлуулалтын хэмжээ тендерийн үнийн саналын мөнгөн дүнгийн 50%-иас багагүй байна/	
3	Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ: / Тендерт ирүүлсэн үнийн саналын мөнгөн дүнгийн 50%-иас багагүй байна/	
4	Ашигтай ажилласан байх: /Сүүлийн 2 жил/	
5	Улс, орон нутгийн төсөвт төлөх татвар, нийгмийн даатгалын шимтгэлийн өр төлбөргүй байх.	
Дээврийн ажлын техникийн шаардлага:		
1	Туршлагатай байх, ижил төрлийн ажил гүйцэтгэсэн тухай мэдээлэл, сүүлийн 2 жилд, баталгаа албан бичиг	
2	Дээврийн ажлын чанарын баталгааг албан бичгээр гарган ирүүлнэ.	
3	Ажлыг хийхдээ календарьчилсан график гаргаж хугацаандаа чанартай хийнэ.	
4	Дээврийг халаадаг хар цаасаар технологийн дагуу чанартай сайн гүйцэтгэнэ.	1411,7м2
5	Дээврээс гадна парпетруу цоройлгон наах хэмжээ	148,4м ²

Харьцуулсан тендерийн материалыг 2017 оны 6 дугаар сарын 2-ны өдрийн 16:00 цагаас өмнө Монголросцветмет ХХК-ийн 406 тоот өрөөнд авчрах.

**Хаяг: Улаанбаатар, Баянзүрх дүүрэг, Энхтайваны өргөн чөлөө 98,
“Монголросцветмет” ХХК-ийн байр, 406 тоот өрөө,
утас: 450060-115, факс: 458380 шуудангийн хаяг: Улаанбаатар 51, ш/х- 002**

МОНГОЛРОСЦВЕТМЕТ ХХК